

ХИЛИЙН БООМТЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛЫН ОЙЛГОЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

С.Энхчимэг

*ДХИС-ийн хил судлалын
магистрант, Хилийн цэргийн
0131 дүгээр ангийн ахлах шалгагч,
ахмад*

Х.Асхар

*ДХИС-ийн Хилийн албаны
сургуулийн Хилийн боомтын
аюулгүй байдал, шалган
нэвтрүүлэх албаны тэнхимийн
профессор, доктор (Ph.D),
хурандаа*

Товч агуулга: Хилийн боомт гэж Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засгийн хөгжил, гадаад харилцааг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд үүнийг дагаад тодорхой үүрэг хариуцлагыг хүлээдэг. Үүний тулд хилийн боомтын үйл ажиллагаа, хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг нарийн зохицуулсан эрх зүйн орчин бүрдсэн байх зүй тогтолтой. Судалгааны ажлын сэдвийн хүрээнд эрх зүйн талаарх ойлголтыг онол талаас нь судлах, хилийн боомтын үйл ажиллагаанд шаардлагатай эрх зүйн орчныг онол, практикт хэрхэн холбох, тайлбарлах, боомтын эрх зүйн орчныг хэрхэн сайжруулах зорилгыг агуулсан болно. Энэхүү өгүүлэлд салбарын эрдэмтэн,

судлаачдын диссертац, нэг сэдэвт бүтээл, түүхэн эх сурвалжийн баримтуудыг цуглуулах, эдгээр баримтуудад тулгуурлан харьцуулах, эрх зүйн онолын харьцуулалт хийж, түүнд дүн шинжилгээ хийх зэрэг судалгааны арга зүйг ашигласан болно.

Түлхүүр үгс: эрх зүй, эрх зүйн бүл, зарчим, тогтолцоо

Удиртгал

Хилийн боомт, хилийн эрх зүйн асуудлыг ярихаас өмнө эрх зүй гэж юу вэ гэдэг ойлголтыг авсан нь зүйтэй гэж үзэж байна. Эрх зүй (англ. law)- Төрд хамаарагдах нийгмийн нэлээд нарийн төвөгтэй үзэгдэл. Эрх зүйг төрөөс тогтоосон, зөвшөөрсөн, хангагдсан олон янзын, нийтээрээ заавал дагаж мөрдөх, зан үйлийн журам хэмээн ойлгодог. Заримдаа эрх зүйг хэн нэгний хөндлөнгийн оролцоогүйгээр төрийн хамгаалалтын дор хувь хүмүүнд хамаарах чөлөөтэй захиран зарцуулах зүйл (С.Нарангэрэл, 2021).

Нэг талаар эрх зүйг хууль зүйн хэм хэмжээний тогтолцоо хэмээн ойлгох тал бий. Нөгөө талаар эрх зүй хэмээх нэр томъёог жам ёсны эрхийг багтаасан эрх зүйн бүх үзэгдлийн цогц хэмээн тайлбарладаг байна.

Эрдэмтэн, судлаачдын бичсэн бүтээлүүдээс энэхүү эрх зүй хэмээх ойлголтын талаар онолын түвшинд судалж үзэхэд эрх зүй (англ. law) гэдэг нь төрд хамаарагдах нийгмийн нэлээд нарийн төвөгтэй үзэгдэл гэж

тайлбарласан байна. Тодруулбал төрөөс тогтоосон, зөвшөөрсөн, хангагдсан олон янзын, нийтээрээ заавал дагаж мөрдөх, зан үйлийн журам хэмээн ойлгогддог. Мөн эрх зүйг хэн нэгний хөндлөнгийн оролцоогүйгээр төрийн хамгаалалтын дор хувь хүмүүнд хамаарах чөлөөтэй захиран зарцуулах зүйл гэж (С.Нарангэрэл, 2021) хууль зүйн нэвтэрхий толь бичигт тайлбарлажээ.

Эрх зүйг хууль тогтоогчийн удирдамж, хэн нэгний дур зоргоороо тогтоосон хэм хэмжээ бус төрөөс хараат бус, тогтмол байнга үйлчлэх, эрхэм дээд өгөгдөл, зарчим, нөхцөл, шударга ёс, жудаг, нинжин сэтгэл, хамгийн үнэт зүйлсийн объектив журам, Мөнх тэнгэрийн өгөгдөл (Бурханы) гэж үздэг. Ингэхлээр хууль тогтоогчийн үндсэн үүрэг нь эрх зүйн энэхүү объектив хэв шинжийг хуульд сайтар тусгахад оршино гэж судлаачид тайлбарлаж, үзэл бодлоо илэрхийлжээ.

Үндсэн хэсэг

Академич С.Нарангэрэлийн үзэж байгаагаар эрх зүй нь тодорхой хэв шинжүүдийг агуулсан байх бөгөөд тэдгээрээс нэн чухал шинжүүдийг дараах хамаарна. Үүнд:

1.Нийтээрээ заавал дагаж мөрдөх нь эрх зүйн хэм хэмжээг хэн нэгэн тодорхой хүнд нэр зааж хандуулаагүй, амьдралын тодорхой нөхцөл байдалд орсон ба заавал дагаж мөрдөх ёстой

тодорхой бус олон тооны этгээдэд хандсан байдгаараа илрэлээ олно.

2.Хэм хэмжээний шинж нь нийгмийн харилцаанд оролцогчдын эрх ба үүргийг бэхжүүлсэн хууль зүйн хэм хэмжээний тогтолцоо байдагт оршино.

3.Төрийн хүсэл зоригийн шинж нь төрийн хүсэл зоригийн шинж нь төрийн хүсэл зоригийг илэрхийлнэ эрх зүй цаг ямагт хүсэл зоригийн илэрхийлэл болдог.

4.Системчлэгдсэн байдал нь нарийн төвөгтэй тогтолцоо бүхий бүрдэл болдогт оршино. Эрх зүйн заалтууд нь хүмүүст тусдаа бус харин бие биетэйгээ харилцан уялдсан нөхцөлдсөн байдлаар үйлчилнэ. Эрх зүйн тогтолцоо нь эрх зүйг бүтээгч субъектийн хүсэл, зоригоос, хүслэнгээс шалтгаалахгүйгээр бодитой оршино.

5.Тодорхойлон хэлбэршүүлсэн байдал нь эрх зүй ямар нэгэн хэлбэрээр илрэхийг харуулна. Эрх зүйн хэлбэр нь эрх зүйн ямар тогтолцоонд хамаарч байгаагаас шалтгаална.

6.Төрийн албадлагаар хангагдсан байдал нь төр эрх зүйн хэм хэмжээг батлан гаргаж, тэдгээрийн хэрэгжилтийг хангана гэсэн үг гэж тайлбарлажээ. (С.Нарангэрэл, 2021)

Иймд эрх зүй гэх ойлголт нь нийгэм болоод бодит байдал, хүний хүсэл зориг, эрх, эрх чөлөө, шударга ёс, төрийн хүсэл зориг, хүний жам ёсны эрх, ашиг

сонирхол, харилцан адилгүй хүсэл, хэрэгцээ шаардлагаар илэрхийлэгддэг ойлголт гэж болохоор байна. Улмаар хүн бүхэнд нээлттэй, хэрэглэх бүрэн боломжтой бөгөөд нийгмийн харилцаанд оролцогч хэн бүхний баримтлах, ухамсарлах зан үйлийн зохицуулагч, үйлчлэгч, тохируулагч нь мөн юм.

Энэ ойлголтын хүрээнд хилийн боомт нь өөрөө иргэдийн хүсэл зориг, эрх, эрх чөлөө, төрийн хэрэгцээ, шаардлагыг хангахад чиглэгдсэн байх объект гэж ойлгогдохоор Монгол Улсын хилийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.12-д “Хилийн боомт нь” гэх нэр томъёоны тайлбарын төгсгөлд “.....газар” (Монгол Улсын хилийн тухай хууль, 2016) гэж тодорхойлсон. Тэгэхээр хилийн боомт нь зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааг улсын хилээр нэвтрүүлэх үйл ажиллагааг зохицуулахад чиглэгдсэн эрх зүйн орчинтой байх зүй тогтлын асуудлын талаар яригдах учиртай болно. Хилийн боомтын үйл ажиллагаа нь өөрөө дан ганц үндэсний хууль тогтоомжийн хүрээнд зохицуулагдах бус эрх зүйн тодорхой хувь хэмжээг эзлэх олон улсын хэм хэмжээний актуудаар шууд зохицуулагддаг онцлогтой юм. Тухайлбал, хил залгаа улс (ОХУ, БНХАУ)-уудын засгийн газар хоорондын байгуулсан иргэд харилцан зорчих хэлэлцээр, Дипломат болон консулын

харилцааны тухай вений конвенц гэх мэт.

Тэгэхээр олон улсын хэм хэмжээний актуудаар боомтын үйл ажиллагаа нь нэгэнт зохицуулагдаж байгаа нь тодорхой олон улсын зарчмыг хангах агуулгын хүрээнд хилийн хяналтын байгууллагуудаас батлан гаргаж буй дүрэм, журам юм. Үүнийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр онолын хүрээнд эрх зүйн зарчмыг тодорхойлсон ойлголтоос тодорхой харагдах болно. Эрх зүйн зарчим гэж чухам юу вэ гэдгийг Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичигт (англ. Legal principle)- Эрх зүйн иж бүрэн номлол буюу төсөөлөл, баримтлал, зан үйлийн ерөнхий суурь зарчим. Эрх зүйн зарчим нь эрх зүйн тодорхой журмаас иш татсан тухайн журмын гаргасан нийтлэг үндэслэлийг тодорхойлсон заалт гэж тайлбарласныг илүү ойлгомжтойгоор хилийн боомтын эрх зүйн зарчмыг тодорхой жишээн дээр тайлбарлахад хилийн боомтод мөрдөх журмыг дурдаж болохоор байна. Энэ мэтчилэн олон жишээг дурдаж болно.

Дараагийн нэг чухал асуудал болох эрх зүйн тогтолцооны ойлголтын хүрээнд эрх зүйн бүлийн тухай ойлголтыг судалж, орууллаа. Эрх зүйн бүл гэдэг англи хэлнээ “Legal system” гэж нэрлэгдэх ба адилавар ойролцоо шинж бүхий бүлэг эрх зүйн тогтолцоо гэж тодорхойлсон

байдаг. Хэв шинжийн хувьд -эх сурвалжийн тогтолцоо, -эрх зүйн тогтолцоо, -хууль зүйн байгууллагын зохих байгуулалт, -эрх зүйн уламжлал гэж хуваагдах бөгөөд дээрх хэв шинжүүдээс хамааран дараах ангилалд хуваагдана.

1.Ром- Германы (эх газрын) эрх зүйн бүл

2.Англи-Америкийн (англи-саксоны) эрх зүйн бүл

Тухайн улсуудын нийгэм, улс төр, эдийн засгийн тогтолцоо, амьдралын хэв маяг, үзэл баримтлалаас хамааран социалист эрх зүй, лалын (мусульманы) эрх зүй, скадиновын эрх зүй, энэтхэгийн эрх зүй, Хятад болон Японы эрх зүй, Африк болон Мадагаскарын эрх зүйн тогтолцоо гэж ялгана гэж үздэг байна. (С.Нарангэрэл, 2021)

Эрх зүйн бүл бол эрх зүйн тогтолцооны үндсэн ойлголтын нэг гэж үздэг. Эрх зүйн бүл гэж тухайн улс орон, бүс нутаг, тив

Хүснэгт 1. Монгол Улсын эрдэмтдийн эрх зүйн бүлийг ангилан авч үзсэн байдлыг харьцуулсан судалгаа

Эрх бүлд ангилан авч үзсэн байдал	Эрдэмтэн, судлаачидын нэр				Ижил төстэй байдал
	академич С.Нарангэрэл	Академич Ж.Амарсанаа	Профессор Ч.Нямсүрэн	Профессор Д.Баярсайхан	
англо-саксоны	+		+		
ром-германы	+		+		
мусальманы	+				

тивийн улс орнуудын эрх зүйн үүсэл, хөгжил, голлох эх сурвалж, түүнийг хэрэглэх арга, эрх зүйн уламжлал, заншил, соёл, эрх зүйн ухамсар зэрэг хүчин зүйлүүдээс хамаарсан эрх зүйн томоохон ангилал буюу бүлэглэлийг ингэж тайлбарлан бичжээ. (О.Амархүү, 2018 он)

Эрдэмтэд, судлаачид сүүлийн үед эрх зүйн бүлийг ром-германы буюу эх газрын эрх зүйн бүл, англи-америкийн буюу жишгийн эрх зүйн бүл, шашны болон овгийн уламжлалт эрх зүйн бүл гэсэн үндсэн ангилалд бүлэглэн авч үзэх болжээ. Тухайлбал, академич С.Нарангэрэл, академич Ж.Амарсанаа, профессор Ч.Нямсүрэн, профессор Д.Баярсайхан нар (О.Амархүү, 2018 он)-ын ангилан үзсэнийг харьцуулан авч үзэхэд дараах нийтлэг болон онцлог хэв шинжүүд ажиглагдаж байгааг хүснэгт 1-ээр харуулав.

эх газрын, нийтлэг эрх зүйн		+			
лалын эрх зүйн		+	+		
уламжлалт эрх зүйн		+	+		
шашны болон овгийн уламжлалт			+		
барууны сонгодог эрх зүйн систем				+	
барууны хосолсон буюу холимог эрх зүйн систем				+	
ойрх дорнодын буюу шашинт эрх зүйн систем				+	
зүүн Ази, Африк дорно дахины буюу заншлын эрх зүйн систем				+	

Агуулгын хувьд харьцуулсан судалгааны үр дүнгээс харахад дараах байдлаар давхцаж байна.

Шашны буюу исламын шашны
Нийгмийн тогтолцоо
Газар зүйн байршилаас нь хамааран

Эх сурвалж. Судлаачийн боловсруулсан хувилбар
Эрх зүйн зарчим (англ. Legal principle)- Эрх зүйн иж бүрэн номлол буюу төсөөлөл, баримтлал, зан үйлийн ерөнхий суурь зарчим. Эрх зүйн зарчим нь

эрх зүйн тодорхой журмаас эш татсан тухайн журмын гаргасан нийтлэг үндэслэлийг тодорхойлсон заалт. (С.Нарангэрэл, 2021) гэж тодорхойлсон байна. Үүнийг хилийн боомтын эрх зүйн зарчмын хүрээнд авч үзэхэд олон улсын хэм хэмжээний актууд болон үндэсний хуульд тодорхойлж өгсөн зарчмуудаас иш татаж тухайн үйл ажиллагаанд үйлчлэх харилцааг зохицуулсан хууль тогтоомжид тусгалаа олж байна. Тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан хүний

эрх, эрх чөлөө, хүний зорчих эрхийг хангах зарчмын хүрээнд тодорхойлогдох хүний эрхийг дээдлэх зарчим. Энэхүү зарчмыг үндэслэн Хил хамгаалах ерөнхий газрын даргын баталсан “Улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх журам”, “Гаалийн хилээр зорчигчийн ачаа тээш, ачаа барааг улсын хилээр нэвтрүүлэх журам” нь дээрх дурдсан зарчмыг бүрэн хангахад чиглэгдэж байна.

Тэгэхээр эрх зүйн зорилго, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд эрх зүйн зарчим нь асуудлыг шийдэхэд гол түлхэц болдог. Эрх зүйн зарчим гэдэг нь эрх зүйн уг сурвалж болсон үзэл санааны эрх зүйн онолын

үндэслэгээ, өөрөөр хэлбэл эрх зүйн харилцаанд оролцогч этгээд нэр бүр үйл ажиллагаандаа удирдлага болох ёстой гол тулгуур үзэл санааны үнэт зүйл нь байдаг. (Б.Ганболд, 2011 он)

Хилийн боомт дахь хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны цар хүрээ, ажлын ачаалал, эрсдэл хэрхэн ялгаатай байгааг судлах зорилгоор нийтлэг мөрддөг олон улсын эрх зүйн баримт бичиг, үндэсний хууль, тогтоомжууд, Засгийн газрын шийдвэр тогтоол, агентлагийн эрх зүйн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, нэгтгэн үзүүлэхэд графикчилан харуулахад дараах үр дүн гарч байгааг график 1, 2-оор харуулав.

График 1. Хилийн хяналтын байгууллагуудаас нийтлэг мөрдөж буй олон улсын гэрээ, конвенц, хэлэлцээр





График 2. Хилийн хяналтын байгууллагуудаас нийтлэг мөрдөж буй Монгол Улсын хууль, УИХ-ын тогтоол, МУ-ын ерөнхийлөгчийн зарлиг



Эх сурвалж: Судалгааны ажлын хүрээнд хийсэн боловсруулалт

Аливаа салбар эрх зүйн харилцаа үүсэх эрх зүйн үндсийг Үндсэн хуулиар тодорхойлдог. Монгол Улсын Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлд Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна, Монгол Улсын хилийг хуулиар бататгана гэж заасан байгаа нь өөрөө хилийн эрх зүйн харилцааны үндэс мөн гэж үзжээ (Хилийн эрх зүй, 2018 он). Хилийн эрх зүй нь бусад салбар эрх зүйн нэгэн адилаар хилийн эрх зүйн аливаа хэм хэмжээгээр зохицуулж байгаа учраас өөрийн гэсэн зохицуулах зүйл, мөн дээрээс нь хилийн эрх зүйн зохицуулалтад ашиглаж буй хууль зүйн арга хэрэгсэлтэй учраас зохицуулалтын аргатай бие даасан салбар эрх зүй юм. Хилийн эрх зүйн тогтолцоо гэдэг нь хилийн эрх зүйн хэмжээг зохицуулж буй харилцааны агуулга, онцлогоос хамаарч

тодорхой эрэмбэ дараалалд оруулан байрлуулсныг хэлнэ. Хилийн эрх зүйн тогтолцоог бүрдүүлэгч анхдагч элемент нь хилийн эрх зүйн хэм хэмжээ юмаа гэж үзжээ. (Хилийн эрх зүй, 2018 он).

Хилийн эрх зүйн хэм хэмжээ гэдэг нь хилийн эрх зүйн шинжийг агуулсан хамгийн жижиг хэсэг учраас дангаараа нийгмийн харилцааг зохицуулах, хамгаалах чадвар дутмаг юм гэж үзэж байгаа юм байна (Хилийн эрх зүй, 2018 он).

Хилийн эрх зүйн тогтолцоо бусад салбар эрх зүйн нэгэн адил ерөнхий анги, тусгай анги гэсэн бүтэцтэй байна. Хилийн эрх зүйн хилийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааны бүх институт, хэсгүүдээс нийтлэг байдлаар хамаарч зохицуулж буй хэм хэмжээнүүдийн нийлбэрийг ерөнхий анги гэж үзнэ.

Хилийн эрх зүйгээр зохицуулж буй нийгмийн харилцаа нь тодорхой төрөл, чиглэлээр ангилагдаж эрх зүйн институт, хэсгүүд болох бөгөөд энэ нь тусгай ангийн системийг бүрдүүлдэг. Тусгай анги нь ерөнхий ангийн үзэл баримтлал, зарчмыг удирдлага болгодог.

Дүгнэлт

Одоогийн хилийн хяналтын байгууллагуудын мөрдөж буй “салангид” хууль, дүрэм, журам заавар нь хилийн боомт болон хяналт шалгалтын байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулахад учир дутагдалтай байгааг эрдэмтэн, судлаачид судалгааны ажлын үр дүнгээр байнга сануулж, хэрхэн сайжруулах талаар өөр өөрийн салбарын түвшинд авч үзэж байна. Энэ байдлыг сайжруулах талаар төрийн зүгээс анхааран бодлогын түвшинд “Алсын хараа-2050 хөгжлийн урт хугацааны хөгжлийн бодлого”, “шинэ сэргэлтийн бодлого” зэрэг баримт бичгүүдийг УИХ-аас батлан гарган хилийн боомтуудын дэд бүтэц, барилга байгууламжийг шинэчлэх, өргөтгөх замаар нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зэргээр тодорхой арга хэмжээг сүүлийн 5 жилд хийж хэрэгжүүлж байгаа юм.

Дан ганц дэд бүтэц, барилга байгууламжийг шинэчилснээр асуудлыг шийдвэрлэх боломжгүй юм. Дээрх дурдагдсан асуудлыг зохицуулах анхдагч эх үүсвэр нь эдгээрийг зохицуулах эрх зүйн

орчин юм. Эрх зүйн орчин тодорхой, нарийн зохицуулалттай байх нь үйл ажиллагааг илүү тодорхой, бусад хэм хэмжээний актуудтай харилцан уялдаатай болгох, нийгмийн болон бусад асуудлыг шийдвэрлэх зэрэг олон талын ач холбогдолтой болох юм. Өнөөдрийн байдлаар монгол улсын эргэн тойронд оршин буй хилийн боомтод хилийн хяналтын байгууллагуудаас мөрдөж буй олон улсын болон үндэсний хууль тогтоомжуудаас бүрдсэн нийт 100 гаруй эрх зүйн хэм хэмжээний актууд байна. Зарим хууль тогтоомжууд хоорондоо харилцан уялдаа холбоогүй, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, хилийн хяналтын байгууллагуудын алба хаагчид өөр өөр нийгмийн хангамж, үйлчилгээг авдаг зэрэг тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх зайлшгүй шаардлага байгаа нь судалгааны ажлын үндэслэл болсон.

Санал

Энэхүү илтгэлийг бичиж байхдаа зөвхөн хилийн эрх зүйн орчин гэж ярихаас илүүтэй хилийн боомтын эрх зүйн орчныг сайжруулахад том түлхэц болох гол хөшүүрэг нь хил хяналтын байгууллагын хамтын ажиллагааг сайжруулахад нэгдсэн нэг мэдээллийн системтэй болгох, мөн дээрээс нь дан ганц барилга байгууламжийн асуудлаас шийдээд хамтын уялдаа холбоотой болохгүй нь ойлгомжтой учраас хилийн

боомтын эрх зүйн орчныг сайжруулахаас гадна үүрэг гүйцэтгэж буй хил хяналтын

байгууллагуудын алба хаагчид нь хилийн боомт гэдэг ойлголтын гол цөм учраас тэдгээрийн амьдрах орчин, ажлын байран дээрх сэтгэл хангаж, хөгжихөд юу саад болж байгаа зэрэг хүчин зүйлсийг илрүүлж, түүнийг багасгах арга замыг чухалчлах нь энэхүү илтгэлийн шинэлэг тал ач холбогдол оршиж байгаа юм.

Эх сурвалж

Б.Ганболд. (2011 он). *Эрх зүй судлал*. Улаанбаатар хот.

С.Нарангэрэл. (2021). *Адмон принт ХХК*. Улаанбаатар хот: Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг.

Монгол Улсын Үндсэн хууль. (1992 он). Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.

Монгол Улсын хилийн тухай хууль. (2016 оны 12 28). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*.

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем:

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=12418>-ээс гаргасан

О.Амархүү. (2018 он). *Эрх зүйн онол*. Улаанбаатар хот. Адмон принт ХХК.

С.Нарангэрэл. (2021 он). *Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг*. Улаанбаатар хот.

Ч.Нямсүрэн (2021 он). Эрх зүйн ерөнхий онол. Уланбаатар хот

Д.Баярсайхан (2023 он). Эрх зүйн онол. Улаанбаатар хот.

Г.Лхагвамаа Ч.Мягмарбаяр (2018 он) Хилийн эрх зүй. Улаанбаатар хот.